



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/34

Дуурсах

“Вакцины зохистой менежмент” сургалт  
уулзалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1, 12.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Вакцины зохистой менежмент сургалт, уулзалтыг 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж дархлаажуулалт хариуцсан сувилагч нарыг хамруулсугай.


2. Сургалтын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, сургалтын хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтанд зарцуулагдах 130.000 (Нэг зуун гучин мянган төгрөг)-ийг нэмэлт тунг идэвхжүүлэх зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (П.Мөнхэрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д даалгасугай.

ДАРГА  ЭНХЖАРГАЛ  
21051109

Эрүүл мэндийн газрын даргын 2022  
оны 05 дугаар сарын 09-ны өдрийн А/Б/Г  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## “ВАКЦИНЫ ЗОХИСТОЙ МЕНЕЖМЕНТ” СУРГАЛТ, УУЛЗАЛТЫН УДИРДАМЖ

### Үндэслэл:

Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг нэмэлт дархлаажуулалтыг эрчимжүүлэх “НЭГ САР”-ын аяныг 2022 оны 04 дүгээр сарын 04-өөс 05 дугаар сарын 04-н хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Уг аяны хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа, дархлаажуулалтын нэмэлт тунгийн хамрагдалтын үр дүнг хэлэлцэн зөвлөлдөх сургалт, уулзалт зохион байгуулах шаардлагатай байна.

**Зорилго:** Сум өрхийн эрүүл мэндийн төвийн дархлаажуулалт хариуцсан сувилагч нарыг чадавхжуулах, шаардлагатай компьютерийн тоног төхөөрөмжөөр хангах.

### Зорилт:

1. Дархлаажуулалт хариуцсан сувилагч нарыг зөөврийн компьютер олгох
2. Дархлаажуулалтын хөтөлбөрийн хэрэгжилт, одоогийн нөхцөл байдал, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл болон хүйтэн хэлхээний горим, хадгалалт тээвэрлэлтийн талаарх мэдлэг хандлагыг сайжруулах
3. Ковид-19 халдварын эсрэг нэмэлт тунгийн дархлаажуулалтын сарын аяныг дүгнэх

**Хугацаа:** 2022 оны 05 дүгээр сарын 13-ны өдөр

### Сургалтын сэдэв:

1. Зөөврийн компьютер гардуулах үйл ажиллагаа
2. Дархлаажуулалтын мөрдөгдөж байгаа тушаал шийдвэрүүд
3. Хүүхдийн жингийн мэдээ, өсөлт хоцролтыг тулгах
4. Үндэсний дархлаажуулалтын хөтөлбөрийн хэрэгжилт цаашид анхаарах асуудал
5. Дархлаажуулалтын анхан шатны маягт хөтлөлт
6. Хүйтэн хэлхээний горим, вакцины ханган нийлүүлэлт, зарцуулалт, хадгалалт
7. Товлолын ба ковидын дархлаажуулалтын хамрагдалт, үр дүн,
8. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл

### Үр дүн:

1. Сургалтанд оролцогчдын дархлаажуулалтын талаарх мэдлэг хандлага сайжирсан байна.
2. Дархлаажуулалт хариуцсан сувилагч нарыг зөөврийн компьютер тоног төхөөрөмжөөр хангасан байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2022  
оны 05 дугаар сарын 09-ны өдрийн...  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

БИОЕ0009

**“Вакцины зохистой менежмент” сургалт, уулзалтын хөтөлбөр**

**Оролцогчид:** 20 сум, 4 ӨЭТөвийн вакцинолог сувиллагч нар

**Хэзээ:** 2022 оны 05 дүгээр сарын 13-ны 10.00 цагт

**Хаана:** ЭМГазрын сургалтын танхимд

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах мэргэжилтэн
1	Бүртгэл	09:00-09:10	НЭМТ мэргэжилтэн Д.Энхтуул
2	Нээлт	09:10-09:20	ЭМГазрын дарга Н.Энхжаргал
3	Вакцинолог сувиллагч нарт зөөврийн компьютер гардуулах үйл ажиллагаа	09:20-09:50	ЭМГ, НЭМТ
4	Дархлаажуулалтын мөрдөгдөж байгаа тушаал шийдвэрүүд	09:50-10:10	НЭМТ мэргэжилтэн Д.Энхтуул
4	Хүүхдийн жингийн мэдээ, хүүхдийн өсөлт, хоцролтын нэрсийг тулгах	10:00-10:30	ЭТХ Найгалмаа
5.	Хог хаягдлын менежмент	10:30-11:00	ХШҮМ Мэргэжилтэн Д.Бямбатогтох
Цайны цаг 11:00-11:30			
5	Үндэсний дархлаажуулалтын хөтөлбөрийн хэрэгжилт цаашид анхаарах асуудал	11:30-12:00	Дархлаажуулалт, ХӨАХ Мэргэжилтэн Д.Энхтуул
5	Дархлаажуулалтын анхан шатны маягт хөтлөлт	12:00-12:30	Дархлаажуулалт, хүйтэн хэлхээ хариуцсан бага эмч Ня.Эрдэнэчимэг
6	Хүйтэн хэлхээний горим, төхөөрөмжийн вакцины ханган нийлүүлэлт, зарцуулалт, хадгалалт	12:30-13:00	Дархлаажуулалт, хүйтэн хэлхээ хариуцсан бага эмч Ня.Эрдэнэчимэг
Завсарлага			
7	Цар тахлын үеийн товллолт ба ковидын дархлаажуулалтын байдал хамралт, үр дүн, цаашид анхаарах асуудлууд	14:00-14:30	Дархлаажуулалт, ХӨАХ Мэргэжилтэн Д.Энхтуул
8	Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл	14:30-15:00	Дархлаажуулалт, хүйтэн хэлхээ хариуцсан бага эмч Ня.Эрдэнэчимэг
Цайны цаг 15:00-15:30			
9	Ярилцлага	15:30-16:00	ЭМГ
9	Хаалт	16:00-16:10	ЭМГ